

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-9

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	4-9
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 12 дугаар сарын 03-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 14 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал;
Чөлөөтэй: Б.Жавхлан;
Тасалсан: Ж.Батсуурь.

Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Б.Баярбаатар: Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай.

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 32¹ дүгээр зүйлд заасан үндэслэлээр өргөн мэдүүлсэн төсвийн төслийг хэлэлцэхэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.1 дэх хэсэгт заасан хугацааг баримтлахгүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69, 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн Монгол Улсын 2025 оны төсвийг эцэслэн баталж дуустал хугацаанд мөрдөж дагана гэсэн хуулийн төслийн

үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 07 минут үргэлжилж, ирвэл зохих 13 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 76.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЁС, ЗҮЙ ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Би хурлаа нээчихье. Байнгын хорооны ирц хүрсэн тул 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 16 цагийн Байнгын хорооны хурал нээснийг мэдэгдье ээ. Өнгөрсөн хурлаар Лодойсамбуу гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсэг 2025 оны төсвийн төслийг Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцэх дэгийн асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байсан. Ажлын хэсэг нийтдээ 7 гишүүнтэй ажиллаад дүгнэлтээ бэлэн болгосон тул Байнгын хорооны хуралд танилцуулахад бэлэн боллоо.

Танилцуулгыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байхгүй юу? Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Ч.Лодойсамбуу танилцуулна. Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн танилцуулгыг хүргэе ээ.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсныг Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90.8-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан төсвийн цаглаврын дагуу жилийн төсвийн төслийг Засгийн газар 9 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлахаар тус тус заасан. Улсын Их Хурал улсын жилийн төсөвт бүхэлд нь хориг тавьсантай холбогдуулан хүчингүй болгосон

тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх тусгайлан зохицуулалт байхгүй байна аа.

Иймд Засгийн газраас жилийн төсвийн төслийг Улсын Их Хурал дээр дурдсан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газар төсвийн төслийг дахин боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлах, цаглавар төсвийн төсөлд тусгах өөрчлөлтийн хүрээг тусгасан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.1-д улсын төсвийн төслийг Улсын Их Хурал 10 дугаар сарын эхний 7 хоногт хэлэлцэж эхлэх ба 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дараах 4 үе шаттайгаар хэлэлцэн батална гэж заасан хугацааг өөрчлөх шаардлага бий болсон.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16.1-д тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг энэ хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж саналаа нэгдсэн хуралдаанд оруулна. Мөн 16.3-д энэ хуулийн 16Э1-т заасан хуралдааны дэгийг нэг удаа зөвхөн тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд мөрдөнө гэж заасны дагуу жилийн төсвийн төслийг Улсын Их Хурал хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Улсын Их Хуралд төсвийн төслийг хэлэлцэн батлахад дээр дурдсан хугацаа хамаарахгүй байх тухай нэг удаа үйлчлэх хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг танилцуулдаг билүү?

Б.Баярбаатар: Танилцуулна аа.

Ч.Лодойсамбуу: Хуулийн төслийг танилцуулъя. Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан хуулийн төслийг танилцуулъя. Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай.

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 32¹ дүгээр зүйлд заасан үндэслэлээр өргөн мэдүүлсэн төсвийн төслийг хэлэлцэхэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.1 дэх хэсэгт заасан хугацааг баримтлахгүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69, 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн Монгол Улсын 2025 оны төсвийг эцэслэн баталж дуустал хугацаанд дагаж мөрдөнө өө гэсэн байна.

Б.Баярбаатар: Лодойсамбуу ажлын хэсгийн даргад баярлалаа. Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Ариунзаяа, Очирбат гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би процессын хувьд асуух гэсэн юм. Сая уншсан танилцуулга яах вэ нөгөө яарч байсан учраас агуулгаараа жоохон зөрүүтэй байна л даа. Жишээлбэл Улсын Их Хурал улсын жилийн төсөвт бүхэлд нь хориг тавьсантай

холбогдуулан хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх тусгайлсан зохицуулалт байхгүй байна аа гэдэг нь бол бид өнөөдөр баталсан хуулиараа энэ зохицуулалтыг бий болгочихсон буюу Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг бол яаралтай горимоор эцэслэн баталсан. Тэгэхлээр одоо процессын хувьд Засгийн газар 2020, 2025 оны улсын төсвөө маргааш өргөн барих гэж байна аа гэж ойлгосон. Тэгэхээр манай энэ дэг Засгийн газрын хууль өргөн барьсан хойно чуулганаар хэлэлцэх гээд байна уу, Эс үгүй бол түүнээс өмнө хэлэлцэх гээд байна уу гэдгээс хамаарч энэ үндэслэл танилцуулга маань бас өөрчлөгдөх гээд байна аа. Тэрнээс биш яг одоо танилцуулсан энэ дэгийн төсөлтэй бол холбоотой ямар нэгэн санал бол асуулт байхгүй ээ. Учир нь ажлын хэсэгт орж ажилласан учраас энэ дээр асуулт байхгүй. Гагцхүү энэ процесстой холбоотой мөн танилцуулгатай холбоотой асуулт.

Б.Баярбаатар: Баасандорж дарга хариулах уу?

Б.Баасандорж: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Яах вэ өнөөдөр бас Төсвийн тухай хуулийн нэмэлт оруулах тухай хуулийг хэлэлцэхэд яг энэ цаг хугацааны асуудлыг гишүүд нэлээн ярьсан. Байнгын хороо чуулган дээр. Тэгэхээр өнөөдөр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдчихсан. Тэгээд хоригийн хугацаа дуусаад маргааш төсвөө өргөн мэдүүлэхээр зүгээр урьдчилсан байдлаар төлөвлөж байсан өнөөдөр чуулганы хэлэлцүүлгээр.

Тэгэхээр Төсвийн тухай хууль дээр нэгэнт яг энэ баталчихсан юм чинь Их Хурал өөрөө асуудлаа тодорхой болгосон. ер нь нөгөө хууль тогтоомжид заасан үндэслэлээр хүчингүй болсон хуультай холбоотой дахин хэрвээ жилийн төсвийг хэлэлцүүлэх юм бол ийм ийм журмаар хэлэлцэнэ гээд тэрэн дээр тодорхой болчихсон учраас, ахиж төсвийн хууль орж ирэх үүднээс энэ Төсвийн тухай хуультай холбоотой энэ нэг удаагийн дэгийг өнөөдөр Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж байгаа гэж ойлгож байгаа. Яах вэ яг процессын хувьд Ариунзаяа гишүүний бас зарим санал сонсогдож байна л даа. Яг 4 дэх өдөр бид нар уг нь чуулганаараа хэлэлцээд баталчих юм шиг. Тэгэхээр бид нарт нөгөө нэг ахиад энэ хуулиа баталсан ч гэсэн Ерөнхийлөгчийн хоригийн хугацаа ахиад Төрийн мэдээлэлд нийтлэх гээд ингээд хугацаанууд байгаа байхгүй юу. Даргын зөвлөл дээр урьдчилж ярьснаар бол ер нь 5 дахь өдрөөс юм уу өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэхээр байгаа юм.

Тэгээд төсөв хэлэлц гэж эхлэхэд нөгөө энэ хууль маань өөрөө хүчин төгөлдөр болчихсон байх ёстой. Тэрийгээ л бид нар сайн бодолцох ёстой гишүүд маань.

Б.Баярбаатар: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Миний асуугаад байгаа зүйл маань юу вэ гэхлээр төсөв өргөн барихаас өмнө энэ хууль маань хүчин төгөлдөр болох ёстой гэсэн үг үү? Тэгэхээр чуулганаар яг энэ Дэгийн тухай хуулийн нэг удаагийн дэгийн тухай хуулийг төсөв өргөн барихаас өмнө хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэхээс өмнө бид нар баталсан байх ёстой юу? Хэрэвзээ өмнө орж ирэх юм бол энд танилцуулагдаж байгаа агуулга нь өөрчлөгдөх байхгүй юу.

Б.Баярбаатар: Баасандорж дарга хариулъя.

Б.Баасандорж: Би бол гишүүд ээ зүгээр миний саналаар бол бид нар энэ хуулийг батлахдаа 2025 оны төсвийн хуулийг өргөн мэдүүлнэ гэж бодохоосоо илүү өнөөдөр бид нар хууль баталчихсан. Энэ хуультай нийцүүлээд Дэгийн тухай хуулийн бас зохицуулалт нь байх ёстой гэдэг үүднээсээ энэ 32¹ дүгээр зүйлтэй өнөөдрийн Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой бид нар дэгийн зүйлээ нэг удаагийн дэгээ хийж байна аа. Ийм зүйл орж ирэхэд бид нар ийм нэг удаагийн дэгээр явна гэдэг талаас нь бас давхар харуулна.

Б.Баярбаатар: Өнөөдрийн баталсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орчихсон шүү дээ. Тэрний 32¹-ээр өргөн мэдүүлсэн хуулийг энэ дэгээр хэлэлцэнэ гэдэг агуулгаар асуудалд хандъя гэж байгаа юм байна. Энэ бас зөв логик л доо. Одоо бид нар чинь Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулахад төсвийг өргөн мэдүүлэхэд ингэж хэлэлцэнэ гээд л Дэгийн хуулиа бид нар хавар баталлаа гэдэгтэй л адилхан байхгүй юу. Намар өргөн мэдүүлэх Төсвийн хуулийг хавар дэгийг нь баталж байгаатай л адилхан байхгүй юу. Тэгэхээр нөгөө дэг өргөн мэдүүлэх нь тодорхой болчихсон учраас тэгээд 1 удаагийн дэг.

Тэгээд өнөөдөр төсвийн хуульд чинь ингээд тодорхой нөгөө заачихсан учраас тэр үндэслэл болгоод л явъя гэсэн саналтай л байгаа юм байна л даа. Тэгэхдээ Ариунзаяа гишүүний хэлж байгаа зөв шүү. Энэ агуулга дээрээ анхаараарай. Аль хэзээний өргөн мэдүүлчихсэн юмыг хэлэлцэх гээд байгаа юм шиг иймэрхүү нөгөө зөрүүтэй ойлголтууд гараад тэгээд энэ дээр чинь гишүүд асуулт асуугаад янз бүрийн томъёолол үүсгээд байвал бас амаргүй байхгүй юу чуулган дээр. Энэ дээрээ манайхан анхаарчих.

Очирбат гишүүн асуулт давхацсан учраас нэрээ татлаа гэж хэлж байна. Ингээд асуулт асууж дууслаа. Санал хэлэх гишүүн байна уу?

Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Баярлалаа. Асуудлыг бас шуурхай шийдвэрлэж байгаад. Тэгээд энэ 2 зүйлийг зүгээр хэлчихмээр байна. Их Хурал дээр ороод энийгээ бид хамгаалж ярих хэрэгтэй.

Нэгдүгээрт хамгийн түрүүнд асуугдах зүйл юу вэ гэхээр миний түрүүний хэлж байсанчлан нэг мөсөн дэгийнхээ хуульд өөрчлөлт оруулъя гэдэг зүйлийг маш олон гишүүн асууна аа. Энийг түрүүн Баярбаатар дарга тайлбарлаж байсан. Ажлын хэсгийн дарга болоод Байнгын хорооны дарга ялангуяа энэ асуудалд байр сууриа хамгаалж, тайлбараа маш сайн бэлдэж ороорой. Тэгэхгүй бол яг энэ байдал чинь яваад энэ чинь нэг мөсөн дэгээ өөрчилбөл яасан гэдэг ийм зүйл явах болов уу гэж бодож байна.

Хоёрт бол түрүүн би хэлэх гэж байгаад бас амжсангүй. Энэ үргэлжлүүлээд ажлын хэсгийг Лодойсамбуу гишүүн ахлаад явж байх нь зарчмын хувьд би зөв болов уу нэг асуудлыг барьж аваад ард нь гарах гарах хүртлээ асуудлаа ингээд эрхлээд явж байгаа гэж харагдах нь зүйтэй болов уу гэж дэмжиж санал хэлэх гэж байсан өнгөрчихлөө. Энийгээ одоо үргэлжлүүлээд хэлчихье ээ гэж бодлоо.

Бас нэг зүйл түрүүн Баасандорж дарга хэлж байсан. Энэ цаглаврыг Их Хурал өөрөө батлахдаа энэ бидний энэ дэвшүүлж байгаа хуулийн төслийн хүрээнд цаглаврыг өөрчилж Их Хурлаас баталж болно гэж түрүүн хэлж байсан шүү дээ.

Энийг бас сайн тайлбарлаж хэлэх нь зүйтэй юм шиг санагдаж байна. Яагаад гэхээр цаглавар дээр бид нар өөрчлөлт хийж болно гэвэл түрүүн Очирбат гишүүн бас хэлж байсан. Цаг хугацааны хувьд амжуулах тийм цаглаварыг энэ хуулийн хүрээндээ шийдвэрлэж боловсруулах боломжийг нээж өгч байгаа юм аа гэдгээ бас тайлбарлах. Энэ 2 бол нэлээн нэлээн чухал болох болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Б.Баярбаатар: Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье.

Ч.Лодойсамбуу: Өмнөх ажлын хэсгээс авхуулаад энэ бол яг анх удаа түүхэндээ тохиолдож байгаа энэ үйл явдал, авсан арга хэмжээтэй холбогдуулаад цаг хугацаанд шахагдаад аягүй хурдтай ажиллах шаардлага гарсан. Тэгээд энэ өмнөх ажлын хэсэг болон энэ удаагийн ажлын хэсгийн өргөн барьж байгаа асуудал яг үндсэндээ бол зарчмын хувьд яг нэг юм. Яаралтайгаар энэ цаг хугацааны хувьд шахуу байгаа учраас энэ асуудлаа хэлэлцэхгүй бол эргээд энэ нэг төр засгийн үйл ажиллагаан дээр хүртэл саад учрах нөхцөл байдал бий болж байгаа. Тийм учраас нэг удаагийн дэгээр явахгүй бол дараа дараа дээр нь энэ яг Дэгийн хуульд өөрчлөлт оруулна гэдэг хууль, тогтоомжийн хуулиараа олон хоног дор хаяж 15 хоног шаардах учраас ийм боломжгүй байгаа гэдэг тайлбараа маргааш чуулган дээр бас давхар хэлье ээ гэж бодож байна. Тэгээд энэ богинохон хугацаанд бас Баасандорж даргатай энэ Тамгын газрын хуульчид бол үнэхээр хонон өнжин энэ их богино хугацаанд их сайн ажилласан гэдгийг ер нь энэ Их Хурлын үйл ажиллагааг нэг Засгийн газрын энэ үйл ажиллагааг нь гацаанаас нь гаргачихъя гэдэг дээр идэвх гаргаж байгаа шүү гэдгийг нь бас сайн зөвлөж тусалж ажиллаж байгаа гэдгийг нь бас хэлэх нь зөв байх аа. Баярлалаа.

Б.Баярбаатар: Гишүүд санал хэлж дууслаа. Би төслийг уншиж танилцуулна. Санал хураалтад бэлдье.

Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай. Өргөн мэдүүлсэн гэдэг үгийг авч хаясан эндээс.

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 32¹ дүгээр зүйлд заасан үндэслэлээр өргөн мэдүүлсэн төсвийн төслийг хэлэлцэхэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.1 дэх хэсэгт заасан хугацааг баримтлахгүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69, 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн Монгол Улсын 2025 оны төсвийг эцэслэн баталж дуустал хугацаанд мөрдөж дагана гэсэн ийм 3 зүйл бүхий төсөл танилцууллаа.

Төсөлтэй холбоотой асуулт асууж санал хэлэх гишүүн байна уу? Лодойсамбуу гишүүн.

Ч.Лодойсамбуу: Энэ төслийнхөө 1 дүгээр зүйл дээр редакцын засвар оруулахгүй бол бас нэг зүйлийг орхигдуулсан харагдаж байна. Төсвийн тухай хуулийн 32¹ дүгээр зүйлд заасан үндэслэлээр өргөн мэдүүлсэн гэдгийн араас

Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин хэлэлцэхэд гээд Монгол Улсын 2025 оны төсөв гэдгээ тодотгож оруулах нь зөв байна. Энэ доор нь байна уу тэ?

Б.Баярбаатар: Тамгын газрынхан саяын саналыг тэмдэглэж аваад оруулаарай. 32¹ дүгээр зүйлд заасан үндэслэлээр өргөн мэдүүлсэн гэдгийн ардаас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин хэлэлцэхэд гэж томъёолж байна шүү.

Дахин гэдгийг нь хасах уу? Дахин гэдгийг нь хасна гэж байна шүү. Би түрүүн дахин гэдгийг нь хассан байхгүй юу. Тийм тэгсэн сая дахь ахиад дахин гэхээр нь би оруулах юм болов уу гэж бодсон юм. Тамгын газар энэ дээр яг томъёолоод оруулаарай.

Төслийг дэмжиж санал хураалт явуулна.

Санал хураалт.

Санал хураалтад 10 гишүүн орсноос 10 дэмжиж 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авч хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэх дэгийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Ёс зүй, дэгийн байнгын хорооны саналаар Нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн дарга Чулуунбилигийн Лодойсамбуу танилцуулна аа.

Хэлэлцэх асуудал дууслаа.

Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

16.31 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА